



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2024/76/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2024 оны 02 дугаар сар 24

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn  
Ахлах аудитор М.Алтантуяа  
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК  
Захирал Г.Саранчимэг  
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com  
Аудитор: О.Мандах  
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	9
4.АУДИТЫН ТАЙЛАН.....	11
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.5.1 Завсрын аудитын талаар .....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Албан шаардлага.....	16
6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Ир эдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг





「 БАЯНХОНГОР СУМЫН 2 ДУГААР 1  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
С.ШҮРЭНЦЭЦЭГ ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/24  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

「 **Өөрчлөлтгүй дүгнэлт** 1

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 611,509.3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 597,979.7 мянган төгрөгийг зарцуулж, төсөвт 9.6 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст харилцах дансанд 13,520.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гарсан нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс бага байна.

5020130

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын 24 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 98.9 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>44,077,096.93</b>	<b>54,337,087.58</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>8,302,460.20</b>	<b>13,520,230.85</b>
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>8,302,460.20</b>	<b>13,520,230.85</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>8,302,460.20</b>	<b>13,520,230.85</b>
31211	Төрийн сангийн харилцах	8,302,460.20	13,520,230.85
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>804,600.00</b>	<b>0</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>804,600.00</b>	<b>0</b>
33510	Байгууллагаас авах авлага	804,600.00	0
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>34,970,036.73</b>	<b>40,816,856.73</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>25,963,386.73</b>	<b>33,649,686.73</b>
35110	Тусгай зориулалттай материал	23,440,386.73	33,163,186.73
35130	Эм боох материал	2,523,000.00	486,500.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>9,006,650.00</b>	<b>7,167,170.00</b>
35410	Бичиг хэргийн материал	1,140,000.00	1,699,400.00
35420	Аж ахуйн материал	4,282,600.00	1,164,500.00
35460	Хүнсний материал	0	719,220.00
35470	Бусад хангамжийн материал	3,584,050.00	3,584,050.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>162,056,275.17</b>	<b>150,405,256.47</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>162,056,275.17</b>	<b>150,405,256.47</b>
39100	Газар	0	0
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>44,456,275.17</b>	<b>32,805,256.47</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,709,668.20	1,585,980.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-8,598,868.20	-1,585,980.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0	0
39204	Хуримтлагдсан элэгдэл	0	0
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	50,043,730.00	41,340,380.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-27,012,353.74	-23,405,155.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,963,061.80	17,037,508.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,557,489.01	-8,971,915.49
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,205,023.00	17,035,759.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-15,419,530.56	-12,070,220.42
39217	Ном	3,123,033.68	1,838,900.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>117,600,000.00</b>	<b>117,600,000.00</b>
39301	Программ хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	117,600,000.00	117,600,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>206,133,372.10</b>	<b>204,742,344.05</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>206,133,372.10</b>	<b>204,742,344.05</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>206,133,372.10</b>	<b>204,742,344.05</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	0	181,448,936.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0	181,448,936.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>195,214,289.90</b>	<b>21,707,428.05</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-380,492,205.10	23,098,456.10
51220	Тайлант үеийн үр дүн	575,706,495.00	-1,391,028.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,919,082.20	1,585,980.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>206,133,372.10</b>	<b>204,742,344.05</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	451,932,760.00	611,255,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,566,760.00	8,258,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	8,566,760.00	8,258,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	210,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	8,566,760.00	2,820,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	5,228,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	443,366,000.00	602,997,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	376,160,700.00	544,497,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	376,160,700.00	544,497,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,205,300.00	58,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,205,300.00	58,500,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	468,938,733.63	611,251,194.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468,938,733.63	611,251,194.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	468,679,939.27	607,756,794.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,496,953.00	397,174,717.06
210101	Үндсэн цалин	230,700,454.08	293,513,035.59
210102	Нэмэгдэл	34,355,673.00	88,890,181.47
210104	Урамшуулал	1,673,170.00	14,771,500.00
210105	Гэрээт ажлын хөлс	17,767,655.92	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,373,525.44	50,283,792.70
210201	Тэтгэврийн даатгал	34,876,209.44	34,219,270.32
210202	Тэтгэмжийн даатгал	390,781.00	4,200,711.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	312,624.00	3,167,837.63
210204	Ажилгүйдлийн даатгал	72,174.00	776,368.78
210205	Эрүүл мэндийн даатгал	721,737.00	7,919,604.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,912,000.00	58,500,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,630,029.00	0
210302	Түлш, халаалт	12,669,615.00	0
210303	Цэвэр, бохир ус	7,112,356.00	0
210304	Байрны түрээс	23,500,000.00	58,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,012,000.00	3,603,450.00
210401	Бичиг хэрэг	403,000.00	3,603,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,609,000.00	0
2105	Нормативт зардал	60,090,805.00	68,764,960.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,859,780.00	192,850.00
210502	Хоол, хүнс	57,231,025.00	68,572,110.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,160.00	0
210604	Урсгал засвар	33,160.00	0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	647,000.00	532,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	647,000.00	532,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,114,495.83	28,897,674.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,898,732.00	14,817,439.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,385,250.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,830,513.83	14,080,235.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	258,794.36	3,494,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	3,484,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	3,484,800.00

005 ТӨРИЙН АУДИТЫН БАГШ УУЛИАГА  
ӨӨРЧЛӨЛТГҮЙ  
САНАА ДҮГНЭЛТ

**Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	258,794.36	9,600.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	258,794.36	9,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-17,005,973.63	3,905.63
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	368,945,424.90	1,394,933.68
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	368,945,424.90	1,394,933.68
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-385,951,398.53	-1,391,028.05

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны үлдэгдэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	443,366,000.00	603,207,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	210,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0	210,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	210,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	443,366,000.00	602,997,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	376,160,700.00	544,497,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	376,160,700.00	544,497,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,205,300.00	58,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,205,300.00	58,500,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	435,063,539.80	596,985,179.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	435,063,539.80	596,985,179.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	434,804,745.44	593,490,779.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	284,663,468.72	397,174,717.06
210101	Үндсэн цалин	211,613,278.88	291,420,438.09
210102	Нэмэгдэл	51,494,233.92	90,798,536.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0
210104	Урамшуулал	3,788,300.00	14,955,742.00
210105	Гэрээт ажлын хөлс	17,767,655.92	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,842,559.72	50,283,792.70
210201	Тэтгэврийн даатгал	25,195,959.72	34,408,412.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,911,400.00	4,011,568.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,329,200.00	3,167,837.63
210204	Ажилгүйдлийн даатгал	582,900.00	776,368.78
210205	Эрүүл мэндийн даатгал	5,823,100.00	7,919,604.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,716,600.00	57,695,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,630,029.00	0
210302	Түлш, халаалт	12,669,615.00	0
210303	Цэвэр, бохир ус	7,112,356.00	0
210304	Байрны түрээс	24,304,600.00	57,695,400.00
2105	Нормативт зардал	53,860,887.00	69,291,330.00
210502	Хоол, хүнс	53,860,887.00	69,291,330.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	241,290.00	795,000.00
210604	Урсгал засвар	241,290.00	795,000.00

**Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	813,100.00	1,072,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	813,100.00	1,072,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,666,840.00	17,178,339.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,969,790.00	14,794,389.59
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,697,050.00	2,383,950.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	258,794.36	3,494,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	3,484,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	3,484,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	258,794.36	9,600.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	258,794.36	9,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	8,302,460.20	6,221,920.65
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	1,004,150.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	1,004,150.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0	1,004,150.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	1,004,150.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	-1,004,150.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	8,302,460.20	5,217,770.65
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	8,302,460.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,302,460.20	13,520,230.85

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0	0	0	0
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Тайлант үеийн үр дүн				
5	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	181,448,936.00	10,919,082.20	13,765,353.90	206,133,372.10
6	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	181,448,936.00	10,919,082.20	13,765,353.90	206,133,372.10
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0	9,333,102.20	9,333,102.20
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	181,448,936.00	10,919,082.20	23,098,456.10	215,466,474.30
9	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-9,333,102.20	0	-9,333,102.20
10	Тайлант үеийн үр дүн	0	0	-1,391,028.05	-1,391,028.05
11	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	181,448,936.00	1,585,980.00	21,707,428.05	204,742,344.05

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>611,509,300.0</b>	<b>597,979,729.4</b>	<b>13,529,570.7</b>	<b>97.8</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>611,509,300.0</b>	<b>597,979,729.4</b>	<b>13,529,570.7</b>	<b>97.8</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>608,024,500.0</b>	<b>594,494,929.4</b>	<b>13,529,570.7</b>	<b>97.8</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>404,583,300.0</b>	<b>397,174,717.1</b>	<b>7,408,582.9</b>	<b>98.2</b>
210101	Үндсэн цалин	262,363,900.0	291,420,438.1	29,056,538.1	111.1
210102	Нэмэгдэл	129,626,700.0	90,798,537.0	38,828,163.0	70.0
210104	Урамшуулал	12,592,700.0	14,955,742.0	-2,363,042.0	118.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>53,259,700.0</b>	<b>50,283,792.7</b>	<b>2,975,907.3</b>	<b>94.4</b>
210201	Тэтгэврийн даатгал	36,217,100.0	34,408,412.9	1,808,687.2	95.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,260,500.0	4,011,568.8	248,931.2	94.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,408,400.0	3,167,837.6	240,562.4	92.9
210204	Ажилгүйдлийн даатгал	852,600.0	776,368.8	76,231.2	91.1
210205	Эрүүл мэндийн даатгал	8,521,100.0	7,919,604.7	601,495.3	92.9
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>57,700,000.0</b>	<b>57,695,400.0</b>	<b>4,600.0</b>	<b>100.0</b>
210304	Байрны түрээс	57,700,000.0	57,695,400.0	4,600.0	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>72,421,400.0</b>	<b>69,291,330.0</b>	<b>3,130,070.0</b>	<b>95.7</b>
210502	Хоол, хүнс	72,421,400.0	69,291,330.0	3,130,070.0	95.7
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>800,000.0</b>	<b>795,000.0</b>	<b>5,000.0</b>	<b>99.4</b>
210604	Урсгал засвар	800,000.0	795,000.0	5,000.0	99.4
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,072,200.0</b>	<b>1,072,200.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,072,200.0	1,072,200.0	0.0	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>18,187,900.0</b>	<b>18,182,489.6</b>	<b>5,410.4</b>	<b>100.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,971,200.0	14,965,789.6	5,410.4	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,216,700.0	3,216,700.0	0.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,484,800.0</b>	<b>3,484,800.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,484,800.0</b>	<b>3,484,800.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,484,800.0	3,484,800.0	0.0	100.0
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>611,509,300.0</b>	<b>611,499,700.0</b>	<b>9,600.0</b>	<b>100.0</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>544,497,100.0</b>	<b>544,497,100.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	544,497,100.0	544,497,100.0	0.0	100.0
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>58,500,000.0</b>	<b>58,490,400.0</b>	<b>9,600.0</b>	<b>100.0</b>
320001	Орон нутгийн төсвөөс	58,500,000.0	58,490,400.0	9,600.0	100.0
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>8,512,200.0</b>	<b>210,000.0</b>	<b>8,302,200.0</b>	<b>2.5</b>
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.0	210,000.0	0.0	100.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	8,302,200.0	0.0	8,302,200.0	0.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.0</b>	<b>8,302,460.2</b>	<b>-8,302,460.2</b>	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.0</b>	<b>13,520,230.9</b>	<b>13,520,230.9</b>	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.0</b>	<b>1.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	0.0	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>23.0</b>	<b>23.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	13.0	13.0	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	9.0	9.0	0.0	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэг нь Бага насны хүүхдийг асран хамгаалах, хүмүүжүүлэх сургах цогц үйл ажиллагаа явуулж хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмших хөгжлийг дэмжих, сургуульд орох бэлтгэлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Тайлант онд Хүүхдийн хүсэл сонирхол, хэрэгцээнд тулгуурласан идэвхтэй, чөлөөт үйл явцад суралцах, хөгжих хамгаалагдсан ээлтэй орчин байж, тэднийг хайрлан хүндэтгэж, бүх талын хөгжлийг дэмжинэ гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна..

Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэг нь 2023 онд удирдах 1, гүйцэтгэх 13, үйлчлэх 9 ажилтан нийт 23 орон тоо батлагдаж, 5 үндсэн бүлэгтэй 172 хүүхдийг хамруулан цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулсан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Бага, дунд боловсролын тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны А/22 дугаар тушаалаар баталсан Боловсролын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг мөрдөж байгаа ба Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,391.0 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8302.4	13,520.2	5,217.80
Авлага	804.6	-	0.00
Бараа материал	34,970.0	40,816.9	5,846.90
Үндсэн хөрөнгө	220,194.50	196,988.50	-23,206.00
хуримтлагдсан элэгдэл	-58,138.20	-46,583.30	11,554.90
<b>Нийт хөрөнгө</b>	<b>206,133.30</b>	<b>204,742.30</b>	<b>-1,391.00</b>
Өр төлбөр			0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	206,133.30	204,742.30	-1,391.00
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>206,133.30</b>	<b>204,742.30</b>	<b>-1,391.00</b>

Эх сурвалж: Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд оны эхэнд 8,302.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй оны эцэст 13,520.2 мянган төгрөгийн өмнөх оноос 5,217.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын үлдэгдэл 5,846.9 мянган төгрөгөөр өмнөх оноос бараа материал өссөн байгаа нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 80,634.0 мянган төгрөг, бусад байгууллагаас 5,228.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй авч үйл ажиллагаанд 80,015.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Тайлант онд 2022 оны 804.6 мянган төгрөгийн авлага барагдуулж, өр төлбөр байхгүй байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 23,206.0 мянган төгрөгөөр өмнөх оноос буурсан нь төсвийн хөрөнгөөр 1,004.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан. Боловсролын ерөнхий газраас хөрөнгө оруулалтаар 2.820.0 мянган төгрөгийн хөрөнгө нийт 3,824.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023.2.13-ны өдрийн 13/08 тогтоолоор 27,030.1 мянган төгрөгийн хөрөнгө акталж хөрөнгийн данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 1,391,0 мянган төгрөгөөр буурснаас 204,742.3 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс өөрчлөлтгүй, тайлант үеийн үр дүн 1,391,0 1 мянган төгрөгөөр буурч , 204,742.3 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 489,854.0 мянган төгрөгөөр төлөвлөж, зарлагыг 489,854.0 мянган төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналаас 75,595.8 мянган төгрөгөөр буурч 414,258.2 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 544,497.1 мянган төгрөг болгож 130,238.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь багш ажилчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71801 (сургуулийн өмнөх боловсрол) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс баталсан 544,497,1 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урьд оны үлдэгдлээс санхүүжих 8,302.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 210.0 мянга, орон нутгийн санхүүжилтээр 58,500.0 мянган төгрөг нийт 611,509.3 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 597,979.7 мянган төгрөгийг зарцуулж, хэмнэгдсэн 13,520.2 мянган төгрөг харилцах дансанд үлдэгдлээр зарцуулагдаагүй байна. Дансны үлдэгдлийн 7,408.6 мянган төгрөг цалингийн зардлаас 2,975.9 мянган нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас, 3,130.0 мянган төгрөг хоолны зардлаас бараа үйлчилгээний зардалд 5410.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бана.

Орон нутгийн төсвөөс олгохоор баталсан 58,500.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр батлагдсан санхүүжилтийн 99.9 хувь буюу 58,490.4 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст орон нутгийн төсвийн санхүүжилтийн харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл 9.6 мянган төгрөгийн улсын орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801 Сургуулийн өмнөх боловсрол				
1	81605 Эрүүл мэндийн дэмжих зардал	1,608,4	1,603,0	5,4	99.66

Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	81807 Хүүхдийн хоолны зардал	72,421.4	69,291.3	3,130.1	95.68
3	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчны зардал	3,277.9	3,277.9	-	100.00
4	81823 Боловсролын байгууллагын багшийн зардал	1,608.4	1,608.4	-	100.00
5	81834 Боловсролын стандарт сургалтын зардал	373,210.8	364,818.2	8,392.6	97.75
6	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	100,672.4	98,680.5	1,991.9	98.02
8	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын төлбөр	210.0	210.0	-	100.00
9	80812 Нийтлэг үйлчилгээ	58,500.0	58,490.4	9.6	99.98
	Нийт дүн	611,509.3	597,979.7	13,529.6	0.73

Эх сурвалж: 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэг нь цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд 72,421.4 мянган төгрөг батлагдаж 3 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй тендер зарлан харьцуулалтын болон гэрээгээр Далай ээж ХХК, Сүүтэй дөрөө ХХК, Цагаан дэнжийн хишиг ХХК-тай хүнсний материал нийлүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр 69,291.3 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авч харин бусад хангамж бичиг хэргийн бараа материалыг шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг 2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч С.Шүрэнцэцэг, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Г.Золзаяа нар зурж, нярваар О. Баяржавхлан нар ажиллажээ.

БНА-2024/76/НА-СТА-ТШЗ



#### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 дугаар улирлын нийт зардлын 368,940.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,534.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 4,150.6 мянган төгрөгөөр тогтоосон гүйцэтгэлийн түвшинд материаллаг байдлыг шинэчлэх шаардлагагүй гэж үзлээ.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 596,084.7 мянган төгрөгийн 53 гүйлгээ, зарлагын 120,145.5 мянган төгрөгийн 44 гүйлгээг бүрэн мэдээлж, Хүнсний материал нийлүүлсэн Далай ээж ХХК-ийн 21,109.8 мянга, Сүүтэй дөрөө ХХК-ийн 16,190.0 мянга, Цагаан дэнжийн хишиг ХХК 17,719.2 мянган төгрөгийн нийт 55,019.0 мянган төгрөгийн тендерийн гэрээг байршуулаагүй зөрчил гарсан байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

*Завсрын аудит хийгдээгүй болно.*

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор М. Алтантуяа гүйцэтгэж, 2 төлбөрийн актыг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	1486.5	2	1486.5	100
Зөвлөмж	1	0	1	-	100
Нийт дүн	3	1486.5	3	1486.5	100

Эх сурвалж: 2 дугаар Цэцэрлэгийн 2023.06.06-ны өдрийн 47 дугаар албан бичиг

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023.06.06-ны өдөр 47 дугаар албан бичгээр ирүүлсэн, төлбөрийн актыг бүрэн барагдуулсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөрчил<sup>1</sup> илэрсэнд албан шаардлага өглөө.

5.1 Албан шаардлага

1.Илрүүлэлт: Шилэн дансны цахим сайтад Хүнсний материал нийлүүлсэн Далай ээж ХХК-ийн 21,109.8 мянга, Сүүтэй дөрөө ХХК-ийн 16,190.0 мянга,Цагаан дэнжийн хишиг ХХК 17,719.2 мянга, нийт 55,019.0 мянган төгрөгийн тендерийн гэрээг байршуулаагүй зөрчил гарсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлнэ гэсэн заалт, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж, зөрчлийг арилган биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага өгөв

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хүнсний материал нийлүүлсэн Далай ээж ХХК-ийн 21,109.8	1				1	55,019.0		

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

мянган, Сүүтэй дөрөө ХХК-ийн 16,190.0 мянган,Цагаан дэнжийн хишиг ХХК 17,719.2 мянган төгрөгийн нийт 55,019.0 мянган төгрөгийн тендерийн гэрээг байршуулаагүй зөрчил гарсан байна.								
Нийт дүн	1				1	55,019.0		



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 2 сарын 23 өдөр

Дугаар 101/14810513/БИА/2024  
176/ИА-СИА-ШУБ.

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим сайтад Хүнсний материал нийлүүлсэн Далай ээж ХХК-ийн 21,109.8 мянган, Сүүтэй дөрөө ХХК-ийн 16,190.0 мянган, Цагаан дэнжийн хишиг ХХК 17,719.2 мянган төгрөгийн нийт 55,019.0 мянган төгрөгийн тендерийн гэрээг байршуулаагүй зөрчил гарсан байна.

Энэ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлнэ гэсэн заалт, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дахь "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж, зөрчлийг арилган биелэлтийг 2024 оны 05 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>.

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар


5040197

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор сумын 2 дугаар Цэцэрлэгийн эрхлэгч С.Шүрэнцэцэг, нягтлан бодогч Г.Золзаяа нарт даалгав<sup>2</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>3</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР:  О.МАНДАХ



<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно